



УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн
баталгааны хөтөлбөрийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Жил бүр төлөвлөгөө гарган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Д.Сайханжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

Усны газрын даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгчийн 2025 оны 17 дугаар сарын
19-ны өдрийн .../19 тушаалын хавсралт



АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ хөтөлбөрийн зорилго нь Усны газрын албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан олон талт үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэх замаар албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг хангах замаар тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

1.2.Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан нь хөтөлбөрийн хууль зүйн үндэслэл болно.

1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим нь:

1.3.1.Хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдсан байх;

1.3.2.Төрийн албан хаагчдын ажил үйлсийг үнэлж цэгнэж, төрийн албаны залгамж халаа болсон нарийн мэргэжил, төрийн үйлчилгээний ач холбогдлыг нийгэм орчиндоо түгээн дэлгэрүүлэх;

1.3.3.Хэрэгжилт ил тод, нээлттэй байх;

1.3.4.Албан хаагч нэг бүрийг хамааруулах;

1.3.5.Манлайлах;

1.3.6.Соён гэгээрүүлэх;

1.3.7.Бүтээлч байх;

1.3.8.Нэгжийн санал, санаачилага, олон улсын төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгт тулгуурлах.

1.4.Төрийн албан хаагчдын сурч боловсрох, мэдлэг чадвараа дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломж, нийгмийн баталгаагаар хангахдаа хэрэгцээ, шаардлагад тулгуулан зохион байгуулалттай, санхүүгийн эх үүсвэртэй, байгууллагын үнэт зүйлийг дээдлэн хүндэтгэж, соёлыг түгээн дэлгэрүүлнэ.

1.5.Энэхүү хөтөлбөрт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын албан хаагчид хамрагдана.

1.6.Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

1.7.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар жил бүр төлөвлөгөө гарган нэгдүгээр улиралд батлуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнана.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Хөтөлбөрийн зорилт

2.1.1.Албан хаагчдын сургалт, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх;

2.1.2.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийг батлагааг хангах;

2.2.Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа. Албан хаагчдын сургалт, мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилтын хүрээнд:

2.2.1.Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд төрийн захиргааны албан тушаалд нийтлэг болон тусгай шаардлага хангасан, тухайн албан тушаалын ангилал, зэрэглэлд ажилласан жилийг баримтлан албан хаагчдыг шатлан дэвшүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.2.Салбарын хүний нөөцийн судалгаа, бодлого, төлөвлөгөөнд үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулж, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.2.3.Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ болон олон улсын сэтгүүлд өөрийн судалгааны бүтээл хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.2.4.Шинээр ажилд томилогдсон ажилтанд ажлын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл, хөдөлмөрийн дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, албан хэрэг хөтлөлт цогц мэдээллийн талаар “танилцах сургалт”-ыг зохион байгуулж, ажлын байрыг урьдчилан бэлдэж, хүлээлгэн өгнө.

2.2.5.Албан хаагчдыг ажлаас чөлөөлөхгүйгээр гадаад хэл, мэдээлэл технологи, программ хангамж, хувь хүний хөгжлийн чиглэлээр чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг танхимаар болон зайнаас суралцах боломжийг бүрдүүлнэ.

2.2.6.Төрийн болон өөрийн хөрөнгөөр давтан сургах, мэргэших, мэргэжлээ дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.3.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд:

2.3.1.Орчин үеийн технологийн болон эрүүл ахуйн шаардлага хангахуйц компьютер, тоног төхөөрөмж, бичгийн хэрэгслийн хангалт, шинэчлэлийг тогтмол хийнэ.

2.3.2.Албан техник, тоног төхөөрмжийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж хувь хүний, төрийн болон албаны нууц алдахдахаас сэргийлэх арга замуудыг нэвтрүүлж, сурган хэвшүүлнэ.

2.3.3.Албан хаагчдын ажлын байрны эрүүл ахуйн стандартыг холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоолгон, дүгнэлт гаргуулан, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

2.3.4.Ажлын байрны дотоод орчны агаарыг цэвэр байлгах нөхцөлийг бүрдүүлэх.

2.3.5.Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээнд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, харшил үүсгэдэггүй, угаагч, ариутгагч бодис ашиглах шаардлага тавина.

2.3.6.Засварлагааны болон ажлын бус цагаар албан хаагчдын амрах өрөө, булан ажиллуулна. Эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулж, албан хаагдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулна.

2.3.7.Албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомж, дотоод журамд заасны дагуу цаг тухай бүрт нь олгоно.

2.3.8.Албан хаагчдын оюуны бүтээл болон бүтээлч санаачилгыг дэмжин 2.3.7-д хамруулж, урамшуулал олгож болно.

2.3.9.Албан хаагчдын гэр бүл, залуучуудыг дэмжих зорилгоор “Ахмадын зөвлөл”, “Эцэг эхийн зөвлөл”, “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг байгуулан, ажиллуулж дэмжлэг үзүүлэн ажиллах.

2.3.10.Албан хаагчдын бага насны хүүхдүүдэд зориулан байгууллагын дэргэд хүүхдийн өрөөг тохижуулна.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

3.1.Албан хаагчдын сурах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

3.1.1.Албан хаагчид хууль тогтоомжид заасан нийгмийн баталгаагаар хангагдаж, төрийн албаны үйл ажиллагаа тасралтгүй, төрийн албаны залгамж тогтвортой байх зарчим хангагдана.

3.1.2.Хүний нөөцийн хувьд чадварлаг, ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн хамт олон бүрдэнэ.

3.1.3.Албан хаагчдын хувь хүний хөгжил, мэргэшлийн ур чадвар бүтээмж дээшилнэ.

3.1.4.Албан хаагчид төрийн албаны ёс зүйг баримтлан, ажлын байрны хамтач эрүүл уур амьсгал, харилцааны эерэг хандлагыг бүрдүүлнэ.

3.1.5.Албан тушаалын чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ.

3.1.6.Албан хаагчдыг шинэ санаа, санаачлага гаргахад эерэг хандлага төрүүлэх замаар бүтээлч байдлыг дэмжлэг болно.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин
1	2	3	4	5	6
1	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Сэтгэл ханамжийн судалгааны үндсэн үзүүлэлтийн хувь өссөн байх	Хувь	Сэтгэл ханамжийн судалгааны хувь > 30	Сэтгэл ханамжийн судалгааны хувь 60 <
2	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан урамшуулал, нэмэгдэл хөлсний тогтолцоог бүрдүүлэх	Ажлын гүйцэтгэлийн бүтээмж, үнэлгээ өссөн эзлэх хувь	Хувь	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 85.6 хувь	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 91 хувь
3	Албан хаагчдын мэргэшсэн сургалт болон гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалтанд хамруулах	Албан хаагчдын мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн албан хаагчдын эзлэх хувь	Хувь	Сургалтанд хамрагдсан судалгаа хувь > 20	Сургалтанд хамрагдсан судалгаа хувь 35 <
4	Албан хаагчдыг хөдөө орон нутагт албан томилолтоор ажиллахад эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж, даатгалд хамруулах	Албан хаагчдыг хамруулсан байдал	Хувь	Даатгалд хамруулсан байдал > 0	Даатгалд хамрагдсан хувь 30 <

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

5.1.2.Байгууллагын жил бүрийн төсөвт тусгасан санхүүжилт;

5.1.3.Төсөл хөтөлбөр, гадаад, дотоодын тусламж, хамтын ажиллагааны хүрээнд бий болгосон дэмжлэг.

ЗУРГАА.БУСАД

6.1.Удирдлага, санхүүгийн хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг жил бүр байгууллагын удирдагад танилцуулсан байна.

6.2.Хууль тогтоомж болон бусад дүрэм, журам, стандартад нэмэлт, өөрчлөлт орсон, цаг үеийн бусад нөхцөл байдал шинэчлэгдсэн зэргээс шалтгаалан хөтөлбөрт тодотгол хийж, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

--oOo--